



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрэм” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн зөвлөлийн дүрмийн 4.1.1, Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрэм”-ийг хавсралтаар баталж, 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан дүрмийг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан), их сургуулийн бүтцийн нэгжүүдийн удирдлагуудад даалгасугай.
3. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан Удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан “ШУТИС-ийн дүрэм”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль (цаашид ШУТИС гэх) нь ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн төрийн өмчийн байгууллага байна.
- 1.2. ШУТИС-ийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, гадаад, дотоод, харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Инновацын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, тэдгээртэй нийцүүлэн баталсан энэхүү ШУТИС-ийн дүрмээр зохицуулна.
- 1.3. ШУТИС-ийн хөгжлийн Алсын хараа:
“Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ.”
- 1.4. ШУТИС-ийн Эрхэм зорилго:
“Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацийг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна.”
- 1.5. ШУТИС-ийн үнэт зүйлс: ШУТИС-ийн хамт олон (багш, судлаач, ажилтан, суралцагч, төгсөгч) бид эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд өөр өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ, бүх төрлийн харилцаанд үүсэх дараах үнэт зүйлсийг баримтлан, дагаж мөрдөнө.
ШУТИС (Шилдэг гүйцэтгэл, Уламжлал, Тэмүүлэл, Инновац, Сайн-хүмүүнлэг засаглал) -лаг байна.
- 1.6. ШУТИС-ийн үйл ажиллагааны зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, шинэ мэдлэг буй болгох, нийгмийн түншлэл, мэдээлэл, мэдлэг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд тулгуурлан судалгаа, инновацын ажлын үр дүнг бизнес, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оршино.
- 1.7. ШУТИС-ийн оршин байгаа хаяг: Монгол Улсын, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 34, Шинжлэх ухаан, технологийн их сургууль.
- 1.8. ШУТИС-ийн оноосон нэрийг англи хэлээр “Mongolian University of Science and Technology” гэх ба товчилсон нэр нь “MUST”, цахим хуудасны нэр нь “www.must.edu.mn” байна.
- 1.9. “Шинжлэх ухаан, технологийн их сургууль” нэрийн албан ёсны товчилсон нэр нь “ШУТИС” бөгөөд энэхүү товчлол нь Монгол улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар тус их сургуулийн эзэмших барааны тэмдгээр баталгаажсан байна.
- 1.10. ШУТИС нь албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн туг, ёслолын хувцас, бэлгэдэлтэй байна.
- 1.11. ШУТИС-ийн харьяаллын байгууллагууд энэхүү “ШУТИС-ийн дүрэм” болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн өөрийн дүрмийг баталж мөрдөнө.

Хоёр. ШУТИС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1. ШУТИС нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: